

ЭРДЭНЭЦАГААН СУМ

2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Хууль, эрх зүй, удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

Сумын Засаг даргын захирамж 98, Тушаал 26, Явсан бичиг 207 гаргаж ажилласан. Ирсэн бичиг 72 үүнээс хариутай 31 бичгийг бүртгэн хариуцсан албан хаагчдаар хариуг шийдвэрлүүлж ажиллаа. Өргөдөл гомдлын мэдээг сар бүрийн 20-ны дотор байгууллагуудаас хүлээн авч 25-ны дотор Сүхбаатар аймагт мэдээг хүргүүлэн ажиллаж байна.

Багийн Засаг дарга нарын хэвлэмэл хуудасны захиалгыг баг тус бүрээр нь нэршилтэй гаргуулах талаар саналыг Сүхбаатар аймгийн төрийн Архивт санал хүргүүлэн ажилласан.

Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон ирсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн болон Архивын улсын үзлэгийн урьдчилсан шалгалтанд шалгуулахад бэлтгэж Архивын өрөө тасалгааг цэвэрлүүлж чийг дулаан хэмжигч, галын хор зэргийг стандартын дагуу байршуулж өрөөний тохижолтонд анхаарч өнгө үзэмжийг нэмэгдүүлж ажилласан.

Мөн Баримт бичиг нягтлан шалгах комисс, Тамга тэмдэг түших албан хаагчийг томилуулж архивын Данс бүртгэл, Дансны бүртгэл, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалт, Түүхчилсэн лавлагаа зэрэгт баяжилт хийж ажилласан.

Хэнтий аймгийн Хоршооны зүүн бүсийн сургалтанд ЖДҮХ-сан мэргэжилтэн болон 5 хоршоологчид оролцов. Нэг хоршоо Төрийн банкнаас 195.0 сая төгрөгийн зээл авсан.

Бичигт боомтоос хураагдаж ирсэн Галын хор, хавтанг үнэлүүлж устгуулах комисс томилуулж галын хорыг улсын орлого болгосон.

Зочид төлөөлөгч байрлуулах гэр буудалд тавигдах шаардлагыг бэлтгэн СЗД-д танилцуулж байгууллагын хурлаар оруулан БЗД нарт өгч ажилласан.

Гудамжины гэрэлтүүлэгт нэмэр болгон ААН-дэд хүсэлт тавин сурталчилгааны самбар байрлуулах санал хүсэлтийг солилцон 12 үйлчилгээний газраар зөвшөөрүүлээд байна.

Шүүхэд архивын лавлагаа болон хүсэлт залруулга зэрэг 4 албан тоотыг явуулсан.

Мэдээлэл технологийн хүрээнд:

- Цахим хуудсанд мэдээ мэдээллийг цаг тухайд оруулсан.
- ЗДТГ-ын төрийн мэдээллийн цаг, дотоод сургалтыг зохион байгуулсан. 7 хоног бүрийн Пүрэв, Баасан гарагуудад. /Видео бичлэг хийсэн/
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зар, мэдээллийг Цахим хуудсаараа шуурхай хүргэж, холбогдох албан газруудад хүргэж ажилласан.
- Болсон үйл явдлыг хальсанд буулгаж, баталгаажуулсан.

Цахим үйлчилгээний хүрээнд:

- Иргэдэд EMongolia-д бүртгэл үүсгэж өгсөн.
- **EMongolia** цахим үйлчилгээний нэгдсэн порталаас иргэдэд лавлагаа үйлчилгээг гаргаж, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг дахин захиалж өгч үйлчилсэн.

Нийгмийн даатгал, Халамжийн чиглэлээр:

2024 оны 01.01-нээс эхлэн хэрэгжиж буй Нийгмийн даатгалын багц хуулийг 18 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажиллалаа. Шинээр 5 иргэнд тэтгэвэр шинээр тогтоон, тэтгэвэрийн хувийн хэргийн шилжилт хөдөлгөөн 1 иргэнд хийж шилжүүлэн ажилласан. Сайн дурын даатгалд 5 иргэн, 0-3 насны эхэд шинээр 1 иргэнийг тус тус хамруулан ажилласан. Малчны сайн дурын даатгалд 4 иргэнийг хамруулан ажиллаж байна. 2024 оны 5-р сарын 9-11 хооронд Нийгмийн даатгалын газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалтанд хамрагдсан. Шинэ программд малчны 89 хүний гэрээг байгуулж ажилласан.

Халамжийн нэгдсэн системийн бүртгэлд жирэмсэн эх, цалинтай эхэд эх, ХБИ-н сунгалт хийлгэсэн иргэн, байнгын асаргаанн сунгалтын ахмад, хүүхэд, ахмадын амралтанд 5 ахмад, шүдны хөнгөлөлтөнд 1 ахмад зэргийг бүртгэн мөнгөнд хамруулсан. Мөн шинэ төрсөн хүүхдүүдийг бүртгэн мөнгөнд хамрууллаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрүүдэд ХАББ-ий жагсаалтыг хүлээлгэж өгсөн ба хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан өрхүүд хүнсээ авахад бэлэн болсон байна. Ахмад настаны тухай хуулийн дагуу өдрийн үйлчилгээнд ахмадын хороотой хамтран 10 ахмад хамруулсан. Алсын оч опетик ХХК суманд ирэн 105 ахмадад хол ойрын харааны шил хийлсэнг программд шивэн оруулсан.

Сургуулийн өмнөх боловсрол:

ЕГҮЗЭР ХУТАГТЫН МУЗЕЙ ХАТАГИНЫ ХАР СҮЛДНИЙ ТАХИЛТЫН ӨРГӨӨ МУЗЕЙ ,сум орон нутгийнхаа Түүх соёл Үл хөдлөх хөшөө дурсгал, соёлын өв, орон нутгийн дурсгалыг танин мэдэх зорилгоор музейгээр Бэлтгэл ,Ахлах бүлгийн хүүхдүүд зочилсон.

“МАНАЙ МУЗЕЙ ГОЁ” сэдэвт гар зургийн уралдаанд амжилттай оролцсон. Амжилттай оролцсон Бэлтгэл А бүлгийн Б.Хосбаяр тэргүүн байр эзэлсэн.

“СУРАГЧ БОЛЛОО” сургуультай танилцах үйл ажиллагаанд Бэлтгэл А,Б,В бүлгийн хүүхдүүд оролцсон.

Анги бүлгүүд тайлант өдөрлөгөө хийж ээж, аавдаа сурч мэдсэнээ тайлагнав. Үүнд: Өнгө, дүрс, тоо, шүлэг, дуу, жимс, хүнсний ногоогоор загварын үзүүлбэр танилцуулсан.

Үндэсний Өв Соёл Монгол бичиг мину МУ-ын ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигаар “Монголын Үндэсний бичиг үсгийн баярын өдөр” –ийг тэмдэглэн үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчилах, үндэсний бичгээрээ бичиж, унших санаачлагыг дэмжин СОНА зохион байгуулдаг уламжлалтай. “Уншлагын аварга” “Сайхан бичигтэн” тус тус тэмцээн зохион байгуулагдсан. “Уншлагын аваргаар бүлгийн багш Д.Эрдэнэболор Тэргүүн байр эзэлсэн.

“Жаргалтай нас- 2024” Бэлтгэл бүлгийн тайлант өдөрлөгөөр аав, ээждээ сурсан мэдсэнээ тайлагнаж амжилттай төгсөж батламжаа гардан авсан .

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Хуйрнан шуугигч” үндэсний бөхийн барилдааныг Эрдэнэцагаан сумын засаг даргын тамгийн газар, Хүүхдийн 1-р цэцэрлэг, Хүүхдийн 2-р цэцэрлэг хамтран зохион байгуулж 4-5 насны хүүхдүүд оролцож Бэлтгэл А бүлгийн Б.Хосбаяр тэргүүн байр эзэлсэн.

Зуны цэцэрлэг 3, 4 дүгээр багруу гарч ажилласан. 2023-2024оны хичээлийн жилийн зорилго, зорилтын биелэлтээ бүлгийн багш, багшийн туслахууд тайлагнасан.

Ахлах тогооч Ц.Эрдэнэбилэг, Туслах тогооч Б.Аринзул нар УБ хотод сургалтанд хамрагдсан.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгууллагын даргын А/15 дугаар тушаалын дагуу албан хаагчиддаа Үндэсний бичгийн уншлагын цагийг баасан гариг бүрийн 14 цагт тогтмол явуулж, цаашид ажилчдын бичгийн чадварыг сайжруулах зорилгоор хичээнгүй бичгийг Мягмар гариг бүрийн 14 цагаас тогтмол хамруулан ажиллаж байна.

1. Сумын 100 жилийн ойн найруулагчийн баг ирж СӨ тээгчдийг цуглуулах, танилцуулах ажил хийгдэж байна.

2. Номын сангийн цахим системийн шинэчлэлттэй холбоотой КОХА цахим системийн сургалтанд номын санч хамрагдлаа.

3. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд хүүхэд багачуудын дунд 7 төрлийн уралдаан тэмцээнийг сумын хүүхэд хамгааллын багтай хамтран зохион байгууллаа. Үүнд: “Эрдэнэцагаан бидний ирээдүйд” эссэ бичлэгийн уралдаан, зургийн уралдаан, дугуйн уралдаан, даамны тэмцээн, гүйлтийн уралдаан, бөхийн барилдаан, дааганы уралдаанууд, дугуйлангийн сурагчид болон хүүхдийн 1,2 дугаар цэцэрлэгийн сурагчдын урлагийн тоглолт зэргийг зохион байгууллаа.

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Номын сангийн уншлага үйлчилгээг тогтмол явуулж 06 сард нийт 70 ирэгсэд, байнгын уншигч 7 хүнд үйлчилгээ үзүүлж 24 номыг олголоо. Холбогдох дээд байгууллагаас ирүүлсэн мэдээ тайлан судалгааг цаг тухайд нь хүргэн ажиллалаа.

2. Номын сангийн программ хангамжид шивэгдсэн ном хэвлэлийн алдааг засаж засварлан нийт 1429 гаруй номыг шивсэн цаашид үлдсэн номоо шивж оруулах ажлаа эрчимжүүлнэ.

3. Мөн Сүхбаатар аймгийн хэмжээний соёлын салбарын түүхэн товчоо номонд өөрийн сумын клуб, соёлын төвд ажиллаж байсан үе үеийн соёлын ажилчдын танилцуулгыг цуглуулах, шивэх ажлыг 90% гүйцэтгэж илгээгээд байна. Дутуу 2 хүний материал, соёлын төвийн түүхийг бүрдүүлэх, баяжуулж байна.

4. Сумын 100 жилийн ойн номонд орох нутгийн зохиолч яруу найрагчдын намтар, бүтээл, мөн соёлын төвийн түүхчилсэн намтар үе үеийн соёлын ажилчдын материалыг бэлтгэн өгөхөөр гүйцэтгэж байна.

5. Мөн ойтой холбогдуулан 2019 оноос хойш салбар салбарын МУ- ын соёлын гавьяат зүтгэлтэн, гавьяат эмч, аварга малчдын зургийг зураач МУУГЗ Ё.Бадарчаар зуруулхаар өгсөн байна.

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Өв тээгч Д.Мөнхөөгийн зохиосон “Орлой Хонгор” дууныхаа нот аяыг бичүүлээд урын сандаа хадгалуулсан. 100 жилийн ойд зориулан Өв тээгч нарыг цуглуулан хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажилдаа орсон .

ЕГҮЗЭР ХУТАГТЫН МУЗЕЙ ХАТАГИНЫ ХАР СҮЛДНИЙ ТАХИЛТЫН ӨРГӨӨ МУЗЕЙ, сум орон нутгийнхаа Түүх Соёлын Үл Хөдлөх Хөшөө дурсгал, соёлын өв, орон нутгийн дурсгалыг сурталчилах зорилгоор гаднаас ирсэн хүмүүс болон хүүхэд багачуудын хүсэлтээр тогтмол музейгээ танилцуулан ажиллаж байна.

Нээлтийн үйл ажиллагаанд 100 хүүхэд оролцуулахаар бэлтгэж байна.

ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.ЭГШИГЛЭНТ АЯЛГУУ дугуйлангын сурагчдыг шинээр бүртгэлжүүлэн Морин хуур , төгөлдөр хуур , ардын дууны сургалтыг зохион байгуулахын зэрэгцээ сумын 100 жилийн ойн баяр наадмын соёл урлагийн арга хэмжээнд СӨ тээгчдийг дуудан оролцуулхаар бүртгэл хийсэн.

Нийтийн шугаман бүжгийн 3 дугаар ээлжийн сургалтыг 8-р багийн иргэн Р.Саранцэцэг төлбөртэй зохион байгуулсан ба манай байгууллагын зүгээс өрөө, танхим гарган өгч хамтран ажиллаж байна.

Хөдөө Аж Ахуйн чиглэлээр:

Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газраас сумдын тасгуудад мониторинг хийж газар дээр ажлуудтай танилцаж. 12 өрх айлаар орж ажилласан. Шалгалтаар зарим үүрэг чиглэлийг хүлээн авч ажил албандаа мөрдөн ажиллаж байна.

1. Шинээр хээлтүүлэгч нөхөн тавих. 2 . шинэ хоршоог иргэдэд сурталчлах, зээлэнд хамруулах ажлуудыг эрчимжүүлэх 3. Хоршооны зээлийн эргэн төлөлтөд анхаарч ажиллах, төвлөрүүлэх

Сумын нийт малтай өрхийн тоо 1324, малчин өрх 1105, малчдын тоо 2003 хүрч малын тоо 498705 толгой болсон байна. Үүнээс тэмээ-644, адуу-60122, үхэр-41892, хонь-212083, ямаа-183964.

Хорогдлын мэдээ: Сумын хэмжээнд Нийт-137583 толгой мал хорогдсон байна. Үүнээс тэмээ-9 адуу-5260, үхэр-13192, хонь-58952, ямаа-55663 буюу 27,6 хувь нь хорогдсон мэдээтэй байна

Хорогдсон том мал бүгд						Эзлэх хувь (хорогдсон том мал)					
Бүгд	Адуу	үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Бүгд	Адуу	үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
137583	5260	13192	9	58952	55663	27.6	8.75	31.5	1.4	29.1	31.2
10669	521	1022		4350	4776	10.67	4.418	10.84	0	9.89	13.76
9000	434	894	3	3318	4351	29.32	12.24	34.17	42.86	26.45	36.29
18997	995	1910	0	7312	8780	28.73	11.83	36.73	0	28.3	32.98
35943	1657	2618	3	18067	13601	57.03	20.55	63.81	1.775	64.17	60.34
2853	182	394	0	1118	1159	10.75	5.089	12.37	0	10.64	12.59
33996	600	3631	1	16794	12970	34.3	6.983	49.87	0.599	36.85	34.58
20395	620	2150		8269	9356	22.99	4.859	27.55	0	23.35	28.67
5730	251	573	2	2537	2367	23.38	7.426	25.23	9.524	25.18	27.03

7 хоног бүрийн 3 дахь өдөр малчид иргэдийн хорогдсон том малын судалгааг баг багаар нь шинэчлэлт хийж онлайнаар хүргэн ажиллаж байна. Улс аймгийн Онцгой комиссын жижүүр өдөр бүр малын хорогдол, эрсдэлтэй өрхүүдийн мэдээллийг багуудаас авч нэгтгэн нэг бааз болгон холбогдох дээд байгууллагад дамжуулж

байна. Улсын онцгой байдлын газар, Үндэсний статистик, Хөдөлмөр халамж, Хөдөө аж ахуй зэрэг газруудад 5 удаа явуулсан болно.

Сэг зэмийн устгалд 3,4-р багт ажиллаж 58050 гаруй бог 12150 бод малын устгалын цэгт хаясан

Малын хорогдлын мэдээг багуудаас өрхөөр нь тулган авч Хөдөө аж ахуйн газар, статистикийн хэлтэс, Хөдөлмөр халамж зэрэг газруудад файлаар хүргүүлж өгсөн

Аймгийн Хөдөө аж ахуйн газраас шалгаруулсан сумдын тасгийн 2023 оны ажлаараа 2 байранд орсон амжилттай байна

Тайлан бичсэн: ХЭЗ,ХШҮ- хариуцсан мэргэжилтэн Д.Жагварал.